

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЯМНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ ШИНЖЭЭЧ САХЪЯАГИЙН АРИУНТУЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт					
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт хувь
1	2	3	4	5			
<b>Зорилт 1. “Яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний баталгаажилтын зохицуулалт, хэрэгжилтэд хяналт тавих” зорилтын хүрээнд</b>							
1	Арга хэмжээ 1.1 Яамны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дун, мэргэшлийн түвшнийг үнэлэх ажилд арга зүйн дэмжлэг үзүүлж, холбогдох шийдвэр гаргана.	Хагас, бүтэн жилийн үнэлгээний дүнг баталгаажуулса н шийдвэр	Тушаал -1	Тушаал, тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг 100% хангасан байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан шинэчилсэн журмын дагуу жилийн 2024 оны эхний хагас болон жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан үнэлэх үнэлгээний багийн нарийн бичгийн даргаар ажилласан.</li> <li>- 2024 оны жилийн эцсийн тайлан хүлээн авах тухай мэдээллийг газар, хэлтсийн дарга нарт ТЗҮГ-ын №342 дотоод меморандумаар хургуулж биелэлтийн хангасан.</li> <li>- Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 301 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 422 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаалын дагуу яамны төрийн захиргааны 83, төрийн үйлчилгээний 7 нийт 90 албан хаагчийн 2024 оны жилийн эцсийн</li> </ul>	06, 12	

				<p>гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газар, хэлтсийн албан хаагчдын цагийн бүртгэл (хоцролт, бүртгэл дутуу)-ийн цахим системээс хагас жилийн байдлаар ажлын цагийн хоцролт, дутуу бүртгэл, өвчтэй чөлөөтэй мэдээллийг гаргаж, үнэлгээний багт хүргүүлэв.</li> </ul>		
2	Дэд арга хэмжээ 1.1.1 Үнэлгээний ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулна.	Ажлын хэсгийн хурал Хурлаас гарсан санал, зөвлөмж	Ажлын хэсгийн хурал-3  Санал, зөвлөмж танилцуулсан хурал-1  Хамрагдсан албан хаагч-85	Ажлын хэсгийн хуралдааныг 3-аас доошгүй удаа зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэр, санал, зөвлөмжийг хамт олны хуралд танилцуулна.	<p>ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/132 дугаар "Үнэлгээ хийх тухай" тушаалаар "Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны эхний хагас жилийн тайлан үнэлэх ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллав.</p> <p>2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/132 дугаар тушаалаар Үнэлгээний багийн бүрэлдэхүүн, удирдамжийг батлуулсан. Нийт албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хянаж, хүлээн авав. Үнэлгээний ажлын хэсгийн 3 удаагийн хуралдааныг зохион байгуулав.</p> <p>Үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тушаал гаргаж, холбогдох журмын дагуу мөнгөн урамшуулал олгох тушаал боловсруулан гаргаж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангав.</p> <p>Үнэлгээний дүнг яамны аппаратын хурал дээр танилцуулж, ХНУМТ-ны системд оруулав.</p>	06,12
3	Арга хэмжээ 1.2 Яамны албан хаагчдын хөдөлмөрийн харилцаатай холбоотой тушаал шийдвэрийг хууль	Боловсруулж батлуулсан тушаалын тоо	A тушаал-32  Б тушаал-277	Хууль тогтоомжид нийцүүлэн ТНБД-ын (А,Б) тушаалыг 100% гаргана.	Яамны албан хаагчдын хөдөлмөрийн харилцаатай холбоотой: <ul style="list-style-type: none"> <li>- ажилд томилох, чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулах, тэтгэмж, чөлөө олгох, гадаад томилолт, мөнгөн урамшуулал олгох зэрэг нийт ТНБД-ын Б тушаал 165</li> </ul>	01-12

	тогтоомжид нийцүүлэн гаргана.			холбогдох хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан. Засгийн газрын тогтоол, холбогдох журам, Хөдөлмөрийн тухай хууль, ТАЗ-ийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлийн тогтоолын дагуу		
4	Дэд арга хэмжээ 1.2.1  Ажилд томилох, чөлөөлөх, сэлгэн ажиллуулах, шилжүүлэн ажиллуулах албан хаагчдын хөдөлгөөний мэдээлэл, тушаалтыг ХНУМС-д оруулна.	Батлагдсан тушаалын тоо, Хөдөлгөөний мэдээлэл	Ажлаас чөлөөлөгдсө н-31  Томилогдсон -28	Сул орон тоог 5%-иас доошгүй нөхнө.  ХНУМС-д тухай бүр хөдөлгөөний мэдээллийг оруулна.	<ul style="list-style-type: none"> <li>- ЭМЯ-ны албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, Засгийн газрын цалин, зэрэглэлийн өөрчлөлттэй холбоотой тогтоолын дагуу албан хаагчдын цалингийн хэмжээг тогтоох, ээлжийн амралтын хуваарь батлах, илүү цаг тооцох, хариуцлагатай жижуурин томилон ажиллуулах, албаны хэсэг байгуулах зэрэг ТНБД-ын А-48 тушаалыг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.</li> </ul>	01-12
5	Арга хэмжээ 1.3  Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын	Шинээр батлагдсан ATT		<ul style="list-style-type: none"> <li>- 2024 оны жилийн эцсийн байдлаар ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн, шилжин ирсэн, шилжүүлсэн, сэлгэн ажиллуулсан болон төрийн албанаас тур чөлөөлөгдсөн хөдөлгөөний мэдээллийг тогтмол гаргаж, нөөцад бүртгэгдсэн иргэдийн мэдээллийг ТАЗ-д холбогдох журмын дагуу хүргүүлсэн. байна.</li> <li>- Хүний нөөцийн сул орон тооны нөхөлтийг хийх зорилгоор БТГ-ын 2, НЭМГ-ын 3, ЭТҮГ-ын 1, ХШУДАГ-ын -1 албан тушаалтын сул орон тоог нийтэд нээлттэй зарлаж, 1 орон тоо нөхөгдсэн.</li> <li>- Тусгай шалгалын дүнд болон ажилд тур томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн, шилжин ажилласан албан хаагчдын мэдээллийг ХНУМТ-ны системд оруулж, хөдөлгөөнийг хийж тогтмолжуулсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2024 оны “Зарим яамдын зохион байгуулалтын бутэц, орон тооны хязгаар батлах тухай” 06, Засгийн газрын 2024 оны 40 дүгээр тогтоол батлагсднаар</li> </ul>	01-12

	ATT-ыг шинэчлэн батлуулах	Нэмэлт, өөрчлөлт хийгдсэн ATT	Батлагдсан ATT-91	<p>ЭМЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн дагуу ТНБД-ын А/99 дүгээр тушаалаар яамны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн чиг үүргийг батлуулав. Чиг үүргийн хүрээнд албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн ТНБД-ын А/131 дүгээр тушаалаар батлуулав.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу төрийн захиргааны 104 ажлын байрны Албан тушаалын тодорхойлолтын харьцуулалтыг хийж, холбогдох материалын хамт Төрийн албаны зөвлөлд албан бичгээр хүргүүлсэн.</li> <li>- Салбарын хяналтын газрын орон нутаг, нийслэл дэх улсын байцаагч нарын албан тушаалын жишиг загварыг Салбарын хяналтын газартай хамтран шинээр боловсруулан Төрийн албаны зөвлөлөөр батлуулсан.</li> </ul>	
--	---------------------------	-------------------------------	-------------------	--	--

**Зорилт 2. “Яамны хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах бодлого, хэрэгжилтийн зохицуулалт, албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулах” зорилтын хүрээнд:**

	Арга хэмжээ 2.1 Яамны албан хаагчдын нийгмийн хамгааллын 2024 оны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлнэ.	Батлагдсан төлөвлөгөө, тайлан	Хөтөлбөрийн зорилт арга хэмжээний гүйцэтгэл 96%	Төлөвлесэн арга хэмжээ 30%-аас доошгүй биелсэн байна.	<p>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд хөтөлбөрийг батлуулсан, 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө шинэчлэн батлуулсан. Үйл ажиллагааны зорилт арга хэмжээ Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, үр чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээний дунд төрийн захиргааны албан хаагчдад 60-100% урамшуулалт олгосон.</li> </ul>	01-06	
--	--	-------------------------------	---	---	---	-------	--

				<ul style="list-style-type: none"> <li>- ЗГ-ын 2024 оны Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор албан тушаалын зэрэглэлээр цалингийн хэмжээ нэг шатлал ахиж, төрийн үйлчилгээний цалингийн доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх тушаал гаргаж, ХНУМТ системд нэмэлт, вэрчлэлт, шинэчлэлтийг хийсэн.</li> <li>- 2023 оны жилийн эцсийн албан хаагчдын гүйцэтгэлийн тайлангийн үр дунд ажлын гүйцэтгэлийн үр дунд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг салбар зөвлөөр хэлэлцүүлж, ЭМ-ийн сайдын тушаал гаргаж, ХНУМТ системд оруулсан. Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 301 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт вэрчлэлт оруулах тухай” 422 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2023 оны “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаалын дагуу яамны төрийн захиргааны 76, төрийн үйлчилгээний 7 нийт 83 албан хаагчийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж ажлыг зохион байгуулсан. 2024 оны эхний хагас жилд нийт 83 албан хаагчдад 147,170,600 төгрөгийн үр дүнгийн урамшуулалт олгосон.</li> <li>- Хөтөлбөрийн Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох зорилтын хүрээнд:</li> <li>- Дотоод журамд заасны дагуу төрийн дээд шагнал авсан албан хаагчид</li> </ul>	
--	--	--	--	---	--

			<p>мөнгөн урамшуулалт 2 газрын 2 албан хаагч -400.0 төг</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тэтгэмж- 2.100.000 төг</li> <li>- Эрүүл мэнд болон бусад шалтгаанаар 14 албан хаагчид цалинтай чөлөө олгосон.</li> <li>- Тэтгэмж: шинээр хүүхэдтэй болсон 7 эцэг, эхэд хүндэтгэл үзүүлж тус тус 300,0 мян төгрөг, ар гэрийн гачигдлын улмаас 10 албан хаагчид Тэтгэмж 17 хүнд 3,650,000 төгрөгийг олгож дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- Холбогдох журмын дагуу илүү цагийн нэмэгдлийг хөлс- 14,245,766 төг тус тус олгох тушаал гаргав.</li> </ul> <p>Хөтөлбөрийн Албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах зорилтын хүрээнд;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Албан хаагчдаас ажиллах нөхцөл байдлын судалгааг Аж ахуйн менежерийн хамт авч, нэгтгэн дүгнэлт гаргасан.</li> </ul> <p>Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эцэг, эхийн зөвлөлтэй хамтран албан хаагчдыг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад газар, хэлстийн албан хаагчдын хуваарь, ажлын цагийн зохицуулалтын хийсэн.</li> </ul> <p>Албан хаагчдын сонирхол, хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагад нийцүүлж чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилтын хүрээнд;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэргийн баяр, арга хэмжээ;</li> </ul> <p>Албан хаагчийн гэр бүлийг дэмжих зорилтын хүрээнд:</p>	
--	--	--	---	--

				<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг, эхийн зөвлөлтэй хамтран хүүхдийн баярын арга хэмжээг хамтран зохион байгуулав.</li> </ul>		
2.1	<p><b>Арга хэмжээ 2.2</b> Яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Хөтөлбөрийн зорилт арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь 94%</p> <p>Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 30%-аас доошгүй биелсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- 2023 оны жилийн эцсийн сургалтад хамрагдсан судалгаа гарган, 2024 оны эхний хагас жилд Эрхэлсэн түшмэлийн 2 газрын дарга төрийн санхүүжилтээр, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад төрийн санхүүжилтээр 1, хувийн зардлаар 2 албан хаагч, Дунд хугацааны мэргэшүүлэх давтан сургалтад 5, төрийн албанад анх томилогдсон албан хаагчдад богино хугацааны сургалтад 4 албан хаагчдыг хамруулсан.</li> <li>- УА-аас зохион байгуулсан богино хугацааны сургалтуудад холбогдох газар, хэлтсийн мэргэжилтнүүдийг оролцуулсан. Үүнд: Төсвийн хөрөнгө оруулалтын шинжилгээ, Засгийн газрын гүйцэтгэлийн үнэлгээ: Улсын хөгжлийг түүчээлэх чадварлаг төрийн албан хаагч зэрэг.</li> <li>- Гадаад сургалтад хамруулах ТНБД-ын нийт 56 тушаал гаргаж, батлуулсан. Нийт 43 албан хаагч гадаадДЭМБ, НҮБ-ын ХАС, Хүүхдийн сан, АХБ болон бусад олон улсын байгууллагын зардлаар 2024 оны эхний 10 сарын байдлаар 33 албан хаагч давхардсан тоогоор 67 удаагийн сургалт, хурал, зөвлөгөөнд хамрагдсан байна сургалт, хурал, зөвлөгөөнд хамрагдсан байна.</li> </ul> <p>Биелэлт-95.4%</p>	01-12	

**Зорилт 3. “Сахилгын шийтгэлийн бүртгэл хөтлөлт, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт, тайлагналтыг хэрэгжүүлэх” зорилтын хурээнд:**

3.1	<p><b>Арга хэмжээ 3.1</b> Яамны Ёс зүйн хяналтын Дэд хороо байгуулах, ўйл</p>	<p>Сахилгын шийтгэл ногдуулсан</p>	<p>Сахилгын шийтгэл авсан албан хаагчийг 50%-</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Улсын Их Хурлын 2023 оны “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль, Монгол Улсын Ёс зүйн хорооны “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” тогтоолын</li> </ul>	06-12	
-----	---	------------------------------------	---	--	-------	--

	ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	шийдвэр, тэмдэглэл	Сахилгын шийтгэлтэй-7 албан хаагч	иар бууруулсан байна.	<p>дагуу Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахаар Эрүүл мэндийн яамны нийт албан хаагчид (96.0%)-аас нууц санал авах ажлыг зохион байгуулсан. Албан хаагчдын хамралт 96 хувь.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэй байхаар тогтоож, яамны албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн A/56 дугаар тушаал гаргаж, ТЗҮГ-ын даргын хамт Ёс зүйн дэд хорооны гишүүдтэй уулзалт хийж, тушаалыг танилцуулав.</li> <li>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 13 дугаар зүйлийн 13.4.1, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын дагуу Яамны ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга, гишүүдэд урамшуулалт олгох ТНБД-ын тушаал гаргаж батлуулсан.</li> <li>ХНУМТ-ны цахим системд урамшууллыг баталгаажуулан оруулсан.</li> </ul>	
--	------------------------------	--------------------	-----------------------------------	-----------------------	---	--

	<b>Дэд арга хэмжээ</b> <b>3.1.1</b> Ёс зүйн хяналтын Дэд хороотой хамтран сургалт зохион байгуулна.	Зохио байгуулсан арга хэмжээ	Сургалт-1 удаа 90%-иас доошгүй хамрагдана. 2 удаа	Ёс зүйн дэд хороотой хамтран Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор профессор С.Нарангэрэлийн лекцийг нийт албан хаагчдын сургалт зохион байгуулсан. Хамрагдалт 92.0%. Яамны албан хаагчдын аппаратын хурал дээр Ёс зүйн дэд хорооноос хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар хамтран мэдээлэл танилцуулав.	01-12		
3.2	<b>Дэд арга хэмжээ</b> <b>3.1.2</b> Албан хаагчдын сахилгын шийтгэлийн бүртгэл, мэдээллийг ХНУМС-д баталгаажуулна.	Системд оруулсан тохиолдлын тоо	Системд бүртгэсэн 7 тохиолдол	Тохиолдлыг 100% системд бүртгэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, яамны Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт хангаагүй 1 албан хаагчид Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунтын хамт сонсгол хийсэн. Сахилгын шийтгэлийн ногдуулах үндэслэл тогтоогдоогүй тул харьялах газар, хэлтсийн даргад нь танилцуулав.</li> <li>- Төрийн албан хаагчийн үүрэг, хариуцсан ажлын гүйцэтгэлийг хангалтгүй биелүүлж, өөрийн хариуцсан чигүүргийн ажил үүргээ биелүүлээгүй, алдаа дутагдал гаргасны улмаас иргэний ирүүлсэн гомдлыг тухай бур шийдвэрлээгүй зөрчил гаргасан 2 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10-д заасны дагуу Өөрт нь ганцаарчилсан сануулах хэлбэрийн сахилгын шийтгэл ногдуулсан. Сахилгын шийтгэлийн бүртгэл мэдээллийн ХНУМТ-ны системд оруулж бүртгэв.</li> </ul>	01-12	

**Зорилт 4. “Яамны албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалт, баталгаажилт, хадгалалт, хамгаалалтын хэрэгжилтийг хангах”**

4.1	<b>Арга хэмжээ 4.1</b> Яамны албан хаагчдын хувийн бүрдэлд нэмэлт шинэчлэх, хадгалалт хамгаалалтыг хариуцна.	Шилжүүлсэн, хүлээлгэн өгсөн хувийн хэрэг – 20  Баяжилт хийсэн -20 хувь	Журмын дагуу бүрдүүлсэн хувийн хэргийн эзлэх хувь	Хувийн хэргийн баяжилт, шинэчлэлт 30%-иас доошгүй хийгдсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын дагуу яамны албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Албан хаагчийн хөдөлгөөн, гүйцэтгэл үр дүнг үнэлсэн үнэлгээний хуудас, гүйцэтгэлийн тайланг тухай бүр баяжилтыг хийсэн.</li> <li>- Шинээр томилогдсон албан хаагчдын төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгч тэнцсэн салбар зөвлөлийн тогтоол, АТГ-аас ирсэн дүгнэлт зэргийг хувийн хэрэгт хавсаргаж байна. Мөн сахилгын шийтгэлийн мэдээллийг тухай бүр "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд оруулсан. Мэргэшүүлэх багц сургалт болон бусад богино, дунд хугацааны сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар зэрэг баяжилтыг албан хаагч бүрээр баяжилтыг хийсэн.</li> <li>- Хувийн хэргийн цаасан болон цахим бүрдүүлэлт, баяжуулалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавин ажиллаж, архивт материалыг хүлээлгэн өгсөн.</li> <li>- Шинээр томилогдсон болон шилжиж ирсэн 20 албан хаагчийн хуюйн хэргийн бүрдлийг хүлээн авч, хянаж баяжилт хийв.</li> </ul>	01-12	
4.2	<b>Арга хэмжээ 4.2</b> Албан хаагчдын хөдөлгөөнтэй холбоотой хувийн хэргийг архивлах, хадгалах, хамгаалах	Чөлөөлөгдсөн, өөр байгууллагад шилжсэн албан хаагчдад хувийн хэргийг хүлээлгэн өгсөн тоо		Албан хаагчдын хадгалалт, хамгаалалтыг хариуцаж ажилласан байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Албан тушаалаас чөлөөлөгдсөн, өөр байгууллагад шилжсэн, өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчдын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын дагуу албан хаагчдад хувийн хэргийг хүлээлгэн өгч, бүртгэлд тэмдэглэсэн.</li> </ul>	01-12	

				<ul style="list-style-type: none"> <li>- Мөн архивт хадгалагдаж байсан тус яаманд өмнө ажиллаж байсан албан хаагчийн хувийн хэргийг холбогдох хүмүүст хүлээлгэн өгсөн.</li> <li>- Албан хаагчдын хувийн хэргийг газар, хэлтсээр төрөлжүүлэн хавтаслалт, нэршил зэргийг нэгэн ижил болгож, доторхи жагсаалтын товъёог шинэчлэн үүсгэсэн,</li> <li>- Албан хаагчийн сургалт, хурал, зөвлөгөөн, албан томилолтын тайланг хувийн хэрэгт нь хавсаргаж тогтмолжуулсан.</li> </ul>	
--	--	--	--	---	--

ТАБ. “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг хэрэгжүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

5.1	<b>Арга хэмжээ 5.1</b> <p>Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийн хангана.</p>	<p>Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь</p>	<p>27 арга хэмжээ</p>	<p>Төлөвлөсөн арга хэмжээ 30%-иас доошгүй хэрэгжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Салбар зөвлөлийн 2023 оны тайланг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2024 оны оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 2/172 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн.</li> <li>- Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний төслийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн, ТАЗСЗ-ийн 2023 оны 01 дүгээр тогтооолоор батлуулсан.</li> <li>- Төрийн захирагааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 2 удаа, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах шалгалтыг 1 удаа зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, тогтоол шийдвэрийг батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</li> <li>- Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох санал, тодорхойлолтыг ТАЗ-д уламжилж, эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох</li> </ul>	01-12
-----	--	--	-----------------------	--	---	-------

					<p>асуудлыг ТАЗ-д уламжилсан. Шийдвэрлэлтийн шатандаа явагдаж байна..</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нэр дээр ирсэн 2 иргэний өргөдлийг шийдвэрлэж, иргэнд болон ТАЗ-д хариуг хүргүүлсэн.</li> <li>- "Төрийн жинхэнэ албаны нөөц бурдүүлэх, нөөц санг ашиглах журам", "Төрийн захирагааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам",, "Төрийн албаны Тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам", "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын шинэчлэл, нэмэлт, өөрчлөлтөд санал боловсруулан ТНБД-ын 2/1660 дугаар албан бичгээр ТАЗ-д хүргүүлэв.</li> <li>- Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлтээр 3 гишүүнийг ТАЗ-ийн тогтооюор батлуулав.</li> </ul>	
5.2	<p><b>Дэд арга хэмжээ 5.1.1</b> Салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлыг батлуулж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавина.</p>	<p>ТАЗС3-ийн тогтоол, хурлын тэмдэглэл, тайлан</p>	<p>Зохион байгуулсан хурал-9</p>	<p>Салбар зөвлөлийн хуралдааныг 3-аас доошгүй зохион байгуулна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- 2019 оны 59 дүгээр тогтооюор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын дагуу ТАЗ-ийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөл 2023 оны төлөвлөгөөг 9 чиг үүргийн хүрээнд нийт 24 арга хэмжээ төлөвлесэн.</li> <li>- Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөл 2024 онд 4 удаа хуралдаж, тусгай шалгалтын комисс байгуулах, тусгай шалгалт зохион байгуулах, нэр дэвшиүүлж санал болгох, зэрэг дэв олгох, ахиулан олгох, төрийн захирагааны Тангараг өргүүлэхтэй холбоотой 6 тогтоол албажуулсан.</li> <li>- ЭМЯ, ЗГХА-ЭМДЕГ, ЗГХА-ЭЭХХЭГ-ын албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн</li> </ul>	

					<p>төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн ТАЗ-ийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, ЭМЯ-ны шинээр-3, ахиулах-7, ЗГХА-ЭМДЕГ-ын шинээр-6, ахиулан олгох-42, ЗГХА-ЭЭХХЗГ-ын шинээр-4, ахиулан 1 албан хаагчид олгох Эрүүл мэндийн сайдын А/123 тушалааар батлуулан холбогдох байгууллагад хүргүүлэв.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу хүний нөөцийн талаарх мэдээллийг цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;</li> <li>- албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах шинэ журмын дагуу ажлын байрны мэдээлэл (ТАЗ-ийн 25 дугаар тогтоолын дагуу 1 албан хаагч шилжингээр томилогдсон)</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох журам</li> <li>- хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;</li> <li>- албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.(ЗГ-ын 2020 оны 301, ЗГХЭГ-ын 98 дугаар тушаал)</li> <li>- салбар зөвлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулсан арга хэмжээ, сургалт, төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалтын зар</li> </ul>	
5.3	Дэд арга хэмжээ 5.1.2 Төрийн тусгай албаны шалгалт	Зохион байгуулсан шалгалтын тоо	Тусгай шалгалт- 7	2-оос доошгүй зохион байгуулна.	- ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзول болон шатлан дэвшиүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу ЭМЯ, ЗГХА-ЭМДЕГ, ЗГХА-ЭЭХХЗГ-ын удирдах	01-12

	зохион байгуулах, сул орон тоог нөхнө.			Сул орон тоог 70%-иас доошгүй нөхөгдөнө.	<ul style="list-style-type: none"> <li>- болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан шалтгаан, үндэслэлийг ТАЗ-д захиалгыг хүргүүлсэн.</li> <li>- Комиссын бүрэлдэхүүн, чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар сул орон тооны тусгай шалгалтын зохион байгуулах комиссын 2 удаа хуралдаж, салбар зөвлөлийн 3 тогтоол батлагдсан.</li> <li>- ЭМЯ-ны 7, ЭМДЕГ-ын 12, ЭЭХХЗГ-ын 8 албан тушаалын ажлын байрны мэдээллийг байршуулан ил тод, нээлттэй байршуулж, бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг хянаж, тусгай шалгалт зохион байгуулсан. Шалгалтын дунд ЭМЯ-1, ЭМДЕГ- 4, ЭЭХХЗГ-2 нийт 7 ажлын байр нөхөгдсөн.</li> </ul>		
5.4	<b>Дэд арга хэмжээ</b> <b>5.1.3</b> Яам болон харьяа байгууллагын хүний нөөцийн хөдөлгөөний мэдээлэл, нэгдсэн бүртгэлийг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Нийт- 106 албан хаагч  Нэгдсэн мэдээний сан, хүний нөөцийн хөдөлгөөний тайлан		Хүний нөөцийн хөдөлгөөнийг тухай бүр цахим системд бүртгэсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Яамны албан хаагчдын 2023 оны жилийн эцсийн байдлаар батлагдсан маягтын дагуу хүний нөөцийн мэдээллийг цахимаар ТАЗ-д хүргүүлсэн.</li> <li>- ХНУМТ цахим системд томилогдсон болон чөлөөлөгдсөн, шилжсэн албан хаагчийн мэдээллийг тухай бүр хөдөлгөөний мэдээллийг оруулж шинэчилсэн.</li> <li>- Албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан жил, хугацааг хянаж, цалингийн програмтай уялдуулан мэдээллийн үнэн зөв байдлыг хангасан.</li> <li>- Албан хаагчдын мэдээллийг Хур системээс татаж, дутуу мэдээлэл болон мэдээлэл зөрсөн албан хаагчидтай бүртгэлийн тулгалт хийсэн.</li> </ul>	01-12	

	<p><b>Дэд арга хэмжээ 5.1.2</b> Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх арга хэмжээг зохион байгуулна.</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээ-1</p>	<p>Хамрагдсан 34 албан хаагч</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээ-1 30-аас доошгүй албан хаагч</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны дэргэдэх салбар зөвлөлөөс "ТӨРИЙН АЛБАНЫ ӨДӨР"-ийг тохиолдуулан Эрүүл мэндийн яамны 5, ЗГХА-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 7, ЗГХА-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2 нийт 14 албан хаагчийг төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.</p>	06-12	
<b>"ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
	<p><b>Арга хэмжээ 6.1</b> Яамны албан хаагчдын аппаратын хурлыг зохион байгуулна.</p>	<p>Зохион байгуулсан хурлын тоо</p>	<p>11 удаа</p>	<p>8-аас доошгүй удаа зохион байгуулсан байна.</p>	<p>2024 оны жилийн эцсийн байдлаар албан хаагчдын аппаратын хурлыг 10 удаа зохион байгуулахад албан хаагчдын оролцоог хангасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- ЭМЯ-ны 2023 оны үйл ажиллагааны товч мэдээлэл</li> <li>- Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудал</li> <li>- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүний эрхийг хангах тухай</li> <li>- Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага, MNS7014:2023. Стандартыг танилуулга</li> <li>- Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн талаар</li> <li>- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авлигаас ангид байх тухай</li> <li>- Хүмүүн байхын учир ёс суртахууны тухай</li> <li>- Гепатит D вирусийн эмчилгээ, эм, эмийн үнийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар</li> </ul>	01-12	

	<b>Арга хэмжээ 6.2</b> Сайд, дэд сайд, ТНБД, удирдлагаас өгсөн нэмэлт ажлыг гүйцэтгэнэ.	Хэрэгжүүлсэн ажлын тайлан	10	Үүрэг даалгаврын биелэлт 90%- иас доошгүй биелэгдсэн байна.	<p>Удирдлагуудын өгсөн үүрэг, даалгаварын дагуу</p> <ul style="list-style-type: none"> <li>- Албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл (тухайн албан тушаалын тодорхийолот, мэргэжил, боловсрол, томилогдсон хугацаа, зэрэг дэв, тусгай шалгалт өгсөн байдал), яамны бүтэц, зохион байгуулалттай холбоотой тушаал, шийдвэр, чиг үүрэг 2015-2023 оны байдлаар, сүл орон тооны мэдээлэл</li> <li>- Салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, “Эмч таниараа бахарья” арга хэмжээ, Сувилагчдын баярын баярын арга хэмжээ болон байгууллага, газраас зохион байгуулсан арга хэмжээнд тухай бүр оролцсон.</li> <li>- Эмч нарын Их хурал, Багийн бага эмч нарын нэгдсэн хурал болон Удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулахад биечлэн оролцсон.</li> <li>- Засгийн газрын 2024 он цомын төлөөх тэмцээн уралдаан зохион байгуулахад хамт олны оролцоог хангаж, амжилттай идэвхитэй оролцсон албан хаагчдад цалингийн нэмэгдэл болон цалинтийн чөлөө олгох тушаал гаргав.</li> </ul>	01-12	
	<b>Арга хэмжээ 6.3</b> ХАСХОМ-ийн тайлан хугацаанд нь гаргаж, мэдүүлнэ.	Баталгаажсан мэдүүлэг	Мэдүүлэг-1	Хугацаанд нь цахим системаар мэдүүлсэн байна.	Холбогдох хуульд заасан журмын дагуу ХАСХОМ-ийг цахим бүртгэн, баталгаажилтын хуудсыг холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгөв.	01-06	
	<b>Арга хэмжээ 6.4</b> Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хууль, хэм хэмжээг мөрдэж ажиллана.	Ёс зүйн зөрчлийн тоо	0	Ёс зүйн зөрчил-0	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, ёс зүйн тухай хуулийг баримтлан ёс зүйн зөрчилгүй ажилласан.</li> <li>- Байгууллагын дотоод журмын хэрэгжилтийг ханган, ажлын цагийг баримтлан ажилласан.</li> </ul>	01-12	

	Арга хэмжээ 6.5 Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх, албан бичиг, өргөдлийг журмын дагуу шийдвэрлэнэ.	Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо	0	Ирсэн албан бичиг, өргөдлийг 100% шийдвэрлэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Эилийн эцсийн байдлаа (2024.12.05-ны өдрийн байдлаар) 190 албан бичиг хүлээн авч, шийдвэрлэлт 98.0 хувь байна.</li> <li>- Иргэн болон албан хаагчдаас нийт 110 өргөдөл, гомдол хүлээн авч, асуудлыг судлан, тушаал шийдвэр, албан бичиг боловсруулан гаргаж, хариуг хургуулсан.</li> </ul>	01-12	
--	--	---	---	--	---	-------	--

#### ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин			
		Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа
1	2	3	4		

“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

	Арга хэмжээ 1.  ТАЗ-өөс зохион байгуулдаг цахим сургалтад хамрагдах	-  ТАЗ-өөс зохион байгуулдаг сургалтад хамрагдсан тоо	Дараах сургалтуудад хамрагdav. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- ТАЗ-өөс зохион байгуулдаг цахим вебинар сургалт</li> <li>- ТАЗ-ийн хүний нөөцийн нэгдсэн системийн цахим програм хангамжийн сургалт</li> <li>- ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийн хэрэглээ</li> <li>- ТАЗ-өөс зохион байгуулсан Төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд мэргэжлийн чиглэл, индексийг хэрэглэх арга зүйн сургалт</li> <li>- Удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагын талаар сургалтад тус тус хамрагdav.</li> </ul>	01-12	100%
1					

	<p>Арга хэмжээ 2.</p> <p>Ажлын байрны чиг үүргийн дагуу Хүний нөөцийн мэргэжилтнүүдийн манлайллыг хөгжүүлэх сургалтад хамрагдах</p>	<p>Холбогдох сургалтад хамрагдсан гэрчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ" сургалт, хэлэлцүүлэг</li> <li>- "Төрийн захиргааны албан тушаалын тусгай шаардлагад тусгагдсан "Мэргэжил" түүнд хийсэн судалгааны хэлэлцүүлэг</li> <li>- Удирдлагын академи, ЗГХЭГ-аас зохион байгуулсан Төрийн албан хаагчдыг чадавхижуулах нь: Хүний нөөцийн удирдлага сэдэвт богино хугацааны сургалт (гэрчилгээтэй)</li> </ul>	01-12	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Яамны хүний нөөцийн хөгжил хариуцсан ахлах шинжээч, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

(Албан тушаал)

(Иэр, гарын үсэг )

(Огноо)